



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улиастай сумын Ерөнхий боловсролын 4-р сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ЗАА-2024/212/НА-СТА-ТШЗ

Цахим  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Улиастай сум

2024 он

хуудас:

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын

тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: [Bat-Undraa@audit.gov.mn](mailto:Bat-Undraa@audit.gov.mn)

Аудитын менежер : Х.Болдбаатар

Утас:99105506

Цахим хаяг: [Boldbaatarkh@audit.gov.mn](mailto:Boldbaatarkh@audit.gov.mn)

Ахлах аудитор: Ц.Оюунсүвд

Утас: 99076038

Цахим хаяг: [oyunsuvdts@audit.gov.mn](mailto:oyunsuvdts@audit.gov.mn)

Аудитор : Г.Уранбаяр

Утас:95183025

Цахим хаяг:[gonchigdorjuranbayr@gmail.com](mailto:gonchigdorjuranbayr@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	<a href="#">4</a>
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	<a href="#">5</a>
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	<a href="#">6</a>
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	<a href="#">7</a>
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл .....	13
4.2 Материаллаг байдал .....	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
5. Аудитын илрүүлэлт .....	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....	<b>16</b>

---

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улиастай, Завхан аймаг  
Утас/Факс: 7046-36-12  
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2024.02.23 № 115

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

УЛИАСТАЙ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН 4 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Ц.АЛТАНГЭРЭЛ -Д

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улиастай сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улиастай сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Улиастай сумын Ерөнхий боловсролын 4-р дүгээр сургууль нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт 1,365.5 сая төгрөгийн, орон нутгийн санхүүжилтийн орлого 115.3 сая төгрөгийн, үнэ төлбөргүй орлого 22.6 сая төгрөгийн, нийт 1,536.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн зарцуулсан байна.

### Аудитын гол асуудал

Улиастай сумын Ерөнхий боловсролын 4-р дүгээр сургууль нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан тодруулгуудад дүгнэлт өгөх аудитаар шагнал урамшууллыг давхардуулан олгосон алдаа зөрчил илэрсэн байна.

### Бусад асуудлын хэсэг

Бараа материалын хөдөлгөөний бүртгэл буруу хийсэн алдаа байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

013050194

Audit(D)Дүгнэлт/2024

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТӨРГӨӨЛӨХ  
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>73,606,893.08</u></b>	<b><u>147,309,058.59</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b><u>3,677,237.98</u></b>	<b><u>114,662,457.64</u></b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	3,677,237.98	114,662,457.64
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	3,677,237.98	114,662,457.64
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b><u>11,045.46</u></b>	
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	11,045.46	
<b>3351</b>	Байгууллагаас авах авлага	11,045.46	
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	69,918,609.64	32,646,600.95
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	69,918,609.64	32,646,600.95
35460	Хүнсний материал		2,921,000
35470	Бусад хангамжийн материал	69,918,609.64	29,725,600.95
35600	Мал амьтад		
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>854,475,852.71</u></b>	<b><u>835,856,464.99</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	854,475,852.71	835,856,464.99
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	818,768,352.71	800,561,464.99
39201	Барилга, байгууламж, орон сууц	728,547,618.04	728,547,618.04
39202	Хуримтлагдсан элэгдэл	-82,501,407.65	-106,875,002.81
39203	Авто-тээврийн хэрэгсэл	15,000,000.00	15,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-15,000,000.00	-15,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	276,968,919.53	320,209,520.29
39206	Хуримтлагдсан элэгдэл	-154,063,180.47	-184,418,342.17
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	95,969,724.84	88,634,242.42
39208	Хуримтлагдсан элэгдэл	-74,406,457.75	-75,674,446.95
39214	Бусад үндсэн хөрөнгө	13,587,429.00	13,587,429.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-13,587,429.00	-13,587,429.00
39217	Ном	28,253,136.17	29,137,876.17
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	35,707,500.00	35,295,00.00
39301	Програм хангамж	2,150,000.00	2,150,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,462,500.00	-1,875,00.00
39303	Бусад биет бус хөрөнгө	35,020,000.00	35,020,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>928,082,745.79</u></b>	<b><u>983,165,523.58</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>928,082,745.79</u></b>	<b><u>983,165,523.57</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	928,082,745.79	983,165,523.57
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	423,221,247.19	423,221,247.19
51101	Өмч: - төрийн	00.00	00.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	63,043,931.44	118,126,709.23
51210	Өмнөх үеийн үр дүн	63,043,931.44	63,043,931.44
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	55,082,777.79

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	441,817,567.16	441,817,567.16
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>928,082,745.79</u></b>	<b><u>983,165,523.58</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,194,190,648.14</b>	<b>1,503,508,932.76</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>974,712,448.14</b>	<b>22,624,032.76</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	974,712,448.14	22,624,032.76
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,168,900.00	3,449,200.00
12000	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,537,600.00	3,331,200.00
12000	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,631,300.00	118,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	887,871,306.59	17,630,199.76
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	80,672,241.55	1,544,633.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,219,478,200.00</b>	<b>1,480,884,900.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,034,862,200.00	1,365,521,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,034,862,200.00	1,365,521,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	933,600.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	933,600.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	183,682,400.00	115,363,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	183,682,400.00	115,363,400.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,241,429,054.51</b>	<b>1,448,426,154.97</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,241,429,054.51</b>	<b>1,448,426,154.97</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,189,354,354.51	1,395,297,388.91
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	836,639,116.56	1,000,645,550.34
210101	Үндсэн цалин	600,529,824.56	699,635,572.94
210102	Нэмэгдэл	191,055,443.00	257,063,527.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,868,000.00	00.00
210104	Урамшуулал	43,185,849.00	43,185,849.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	105,040,900.00	127,445,575.46
210201	Тэтгэврийн даатгал	72,689,948.68	84,419,575.46
210202	Тэтгэмжийн даатгал	8,087,737.83	10,756,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,470,210.26	8,605,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,617,527.57	2,151,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,175,475.66	21,513,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	131,911,600.00	108,435,833.94
210301	Гэрэл, цахилгаан	11,398,598.04	10,568,733.94
210302	Түлш, халаалт	117,752,001.96	94,436,100.00
210303	Цэвэр, бохир ус	2,761,000.00	3,431,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	13,297,631.91	41,737,641.69
210401	Бичиг хэрэг	13,297,631.91	00.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	41,737,641.69

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,500,000.00	4,000,000.00
210604	Урсгал засвар	2,500,000.00	4,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	9,257,700.00	8,514,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,537,600.00	1,051,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,720,100.00	7,463,300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	90,707,406.04	104,518,287.48
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,703,500.00	25,784,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,393,700.00	11,195,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	51,610,206.04	67,539,287.48
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	52,074,700.00	53,128,766.06
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	52,074,700.00	50,201,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	52,074,700.00	50,201,200.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	00.00	2,927,566.06
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	2,927,566.06
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>952,761,593.63</b>	<b>55,082,777.79</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>929,016,345.79</b>	<b>55,082,777.79</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,224,713,500.00</b>	<b>1,484,334,100.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>6,168,900.00</b>	<b>3,449,200.00</b>
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	6,168,900.00	3,449,200.00
12000	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,537,600.00	3,331,200.00
12000	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,631,300.00	118,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,218,544,600.00</b>	<b>1,480,884,900.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,034,862,200.00	1,365,521,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,034,862,200.00	1,365,521,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	933,600.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	00.00	115,363,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	182,748,800.00	115,363,400.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,179,076,262.02</b>	<b>1,342,059,180.34</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,179,076,262.02</b>	<b>1,342,059,180.34</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,127,001,562.02</b>	<b>1,286,009,414.28</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	836,650,162.02	1,000,645,550.34
210101	Үндсэн цалин	600,540,870.02	699,635,572.94
210102	Нэмэгдэл	191,055,443.00	257,063,527.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,868,000.00	00.00
210104	Урамшуулал	43,185,849.00	43,946,450.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	105,040,900.00	127,434,530.00

210201	Тэтгэврийн даатгал	72,689,948.68	84,408,530.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,087,737.83	10,756,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,470,210.26	8,605,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,617,527.57	2,151,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,175,475.66	21,513,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>131,911,600.00</b>	<b>108,435,833.94</b>
210301	Гэрэл, цахилгаан	11,398,598.04	10,568,733.94
210302	Түлш, халаалт	117,752,001.96	94,436,100.00
210303	Цэвэр, бохир ус	2,761,000.00	3,431,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,500,000.00</b>	<b>2,500,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	00.00
210604	Урсгал засвар	2,500,000.00	4,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,257,700.00</b>	<b>8,514,500.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,537,600.00	1,051,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,720,100	7,463,300
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>41,641,200.00</b>	<b>36,979,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,127,500.00	25,784,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,513,700.00	11,195,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>52,074,700.00</b>	<b>56,049,766.06</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>52,074,700.00</b>	<b>53,122,200.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	52,074,700.00	53,122,200.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>00.00</b>	<b>2,927,566.06</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	2,927,566.06
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>45,637,237.98</u></b>	<b><u>142,274,919.66</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>41,960,000.00</b>	<b>31,289,700.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>41,960,000.00</b>	<b>31,289,700.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>41,960,000.00</b>	<b>31,289,700.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	41,960,000.00	31,289,700.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-41,960,000.00</u></b>	<b><u>-31,289,700.00</u></b>
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	3,677,237.98	110,985,219.66
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	3,677,237.98
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,677,237.98	114,662,457.64

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	423,221,247.19	441,817,567.16	-865,972,414.35	-933,600.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	423,221,247.19	441,817,567.16	-865,972,414.35	-933,600.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	929,016,345.79	929,016,345.79
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	423,221,247.19	441,817,567.16	63,043,931.44	928,082,745.79
	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	423,221,247.19	441,817,567.16	63,043,931.44	928,082,745.79
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	423,221,247.19	441,817,567.16	63,043,931.44	928,082,745.79
	Тайлант үеийн үр дүн			55,082,777.79	55,082,777.79
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	423,221,247.19	441,817,567.16	118,126,709.23	983,165,523.58

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,381,063,500.00	1,257,985,480.34
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,381,063,500.00	1,257,985,480.34
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,321,695,700.00	1,204,863,280.34
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,102,108,300.00	1,000,645,550.34
210101	Үндсэн цалин	768,716,100.00	699,635,572.94
210102	Нэмэгдэл	293,165,000.00	257,063,527.40
210104	Урамшуулал	40,227,200.00	43,946,450.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	137,763,700.00	127,434,530.00
210201	Тэтгэврийн даатгал	93,679,300.00	84,408,530.00
210202	Тэтгэмжийн даатгал	11,021,100.00	10,756,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,816,900.00	8,605,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,204,200.00	2,151,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	22,042,200.00	21,513,100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	12,210,000.00	8,514,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,746,700.00	1,051,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,463,300.00	7,463,300.00
210807	Газрын төлбөр	00.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	69,613,700.00	68,268,700.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	58,418,700.00	57,073,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,195,000.00	11,195,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	59,367,800.00	53,122,200.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	59,367,800.00	53,122,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	59,367,800.00	53,122,200.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,381,063,500.00	1,368,970,700.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,365,521,500.00	1,365,521,500.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,365,521,500.00	1,365,521,500.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САНХҮҮЖИЛТ	15,542,000.00	3,449,200.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,746,700.00	3,331,200.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	118,000.00	118,000.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	3,677,300.00	00.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгэл	00.00	3,677,300.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	114,662,457.64
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	58.00	58.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	35.00	35.00
620003	Үйлчлэх ажилтан	22.00	22.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улиастай сумын Ерөнхий боловсролын 4-р сургууль нь Манай сургууль нь 2 ээлжээр хамран сургах тойргийн 503 сурагч, 59 орон тоотой сургалт хүмүүжлийн ажлаа явуулж байна. Нийт багшлах бүрэлдэхүүний дотор магистр 9, тэргүүлэх 15, заах аргач 9, нийт багшийн 69 хувь нь мэргэжлийн зэрэгтэй, мэргэжлийн багшаар бүрэн хангагдсан. Манай хамт олон Боловсролын салбарын чанарын шинэчлэл, бага, суурь, ахлах боловсролын шинэчилсэн цөм хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж, хүүхэд нэг бүрийн хөгжил, авьяасыг дэмжин уламжлалт ёс заншил түүх соёлоо мэддэг өөртөө итгэлтэй, чадварлаг иргэн төлөвшүүлэхийн төлөө хамтран ажиллаж байна. Манай сургууль нь энэ хичээлийн жилд сургуулийн бүтэц, үйл ажиллагааны хөтөлбөрөө БШУ-ын яам, аймгийн БШУГ-ын зорилго, зорилттой уялдуулан дараах зорилго, зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна.

**ЗОРИЛГО:** Хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа оролцоог хангаж хичээл сургалтын үйл ажиллагааг хосолсон сургалтын арга зүйтэй хослуулан үр дүнтэй зохион байгуулах.

**ЗОРИЛТ-1:** Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ.

**ЗОРИЛТ-2:** Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ.

**ЗОРИЛТ-3:** Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ.

ЗОРИЛТ-4: Байгууллагын бусад ажил чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ.

ЗОРИЛТ-5: Нэмэлт ажил чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

#### ***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:***

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

***Байгууллагын дотоод хяналтын талаар:*** Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Ерөнхий боловсролын сургуулийн дэргэд дотоод аудитын чиг үүрэг бүхий аудитор, дотоод хяналтын нэгж байхгүй байна. Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд сургуулийн захирал, санхүүгийн албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улиастай сумын Ерөнхий боловсролын 4-р сургууль нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Улиастай сумын Ерөнхий боловсролын 4-р сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 100,003.39 мянган төгрөгөөр буюу 4.1 хувиар өссөн байна.

**Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт**

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	69,918.60	32,646.60	(37,272.00)
Үндсэн хөрөнгө	854,475.80	835,856.50	(18,619.30)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>928,082.70</b>	<b>983,165.50</b>	<b>(55,082.80)</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	928,082.70	983,165.50	(55,082.80)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>928,082.70</b>	<b>983,165.50</b>	<b>55,082.80</b>

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

Тайланд онд

Бараа материал эхний үлдэгдэл 69,918.6 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 82,727.2 мянган төгрөг, үнэ төлбөргүй 1,544.6 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж зарцуулсан 121,543.8 мянган төгрөгөөр тус тус хасагдаж, эцсийн үлдэгдэл 32,646.6 мянган төгрөг болж өмнөх оноос 37,272.0 мянган төгрөгөөр өсөж акталж устгасан бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр 31,289.7 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй 17,630.1 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авч, 12,130.0 мянган төгрөгийн хөрөнгө данснаас хасаж жилийн эцэст 835,856.5 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 67,539.2 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 55,082.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,274,305.70 мянган төгрөгөөр нийт зарлагыг 1,274,305.70 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,365,521.5 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлсэн байна. Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 3,677.2 мянган төгрөгийг эрх нээлгэж зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,257,985.4 мянган төгрөг буюу 92.1 хувийн гүйцэтгэлтэй

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Хөтөлбөр, арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>Улсын төсвөөс санхүүжих</b>					
<b>71801</b>	<b>Сургуулийн өмнөх боловсрол</b>				
81605	Эрүүл мэндийг дэмжих	2,985.30	2,985.30		<b>100%</b>
81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	-	-		<b>0%</b>
81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	31,289.70	31,289.70		<b>100%</b>
81823	Боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх	6,717.00	6,717.00		<b>100%</b>
81832	Нүүдлийн бүлэгт хамруулах				
81834	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	1,052,586.80	1,143,802.6		<b>100%</b>
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	180,726.90	180,726.90		<b>100%</b>
		1,274,305.70	1,365,521.5		

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй байдаг ба нэмэлт санхүүжилтээр 1 хөтөлбөрийн хүрээнд 1 арга хэмжээг 115,363.4 мянган төгрөгийн санхүүжилт авч тогтмол зардалд зарцуулсан байна.

<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>					
<b>71801</b>	<b>Сургуулийн өмнөх боловсрол</b>				
80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	115,363.40	115,363.40		<b>100.00%</b>
<b>НИЙТ</b>		<b>115,363.40</b>	<b>115,363.40</b>		<b>100.00%</b>

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

/мянган төгрөг/

№	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1	Харьцуулалтын арга	Хүүхдийн хоол – Мах	19,420.00	19,420.00
2	Харьцуулалтын арга	Хүүхдийн хоол – Хүнсний ногоо	3620.3	3620.3

3	Харьцуулалтын арга	Хүүхдийн хоол – Сүү, цагаан идээ	6669	6669
4	Харьцуулалтын арга	Хүүхдийн хоол – бусад хүнсний материал	23072.9	23072.9
5	Харьцуулалтын арга	Хүүхдийн хоол – Талх, нарийн боов	0	0
5	Шууд гэрээ байгуулах	Түлш халаалт	94436.1	94436.1
6	Шууд гэрээ байгуулах	Гэрэл цахилгаан	10568.7	10568.7
7	Шууд гэрээ байгуулах	Цэвэр, бохир ус	3431	3431
8	Шууд худалдан авалт	Урсгал засвар	4000	4000
9	Шууд худалдан авалт	Харилцаа холбооны зардал	699.3	699.3
10	Шууд худалдан авалт	Эрүүл мэндийг дэмжих үйлчилгээ	2985.3	2985.3
11	Шууд худалдан авалт	Сургалтын хөтөлбөр		
12	Шууд худалдан авалт	Сургалтыг дэмжих бусад үйлчилгээ	1492.7	1492.7
	ДҮН		170,395.30	170,395.30

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

#### 4. АУДИТЫН ТАЙЛАН

##### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Улиастай сумын Ерөнхий боловсролын 4-р сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хаан соёмбо аудит ХХК-ийн гэрээт аудитор Г.Уранбаяр гүйцэтгэж, хяналтыг Хаан соёмбо аудит ХХК-ийн захирал Х.Диймаа анхан шатанд хянаж, Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд, аудитын менежер Х.Болдбаатар нар хоёр дахь шатанд, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа дараагийн шатанд хяналтыг хэрэгжүүлсэн.

Улиастай сумын Ерөнхий боловсролын 4-р сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хаан соёмбо аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 06 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

## **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 598,700.0 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 8,890.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 6,735.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоож 2023 оны хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,448,426.1 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 21,726.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 16,294.7 мянган төгрөгөөр тогтоолоо.

## **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 29 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа зөрчил илрээгүй байна.

## **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Улиастай сумын Ерөнхий боловсролын 4-р сургуулийн 2023 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийж гүйцэтгээгүй байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж 1 төлбөрийн актыг бүрэн барагдуулж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,550.0	1	1,550.0	100
Зөвлөмж	2	0	2	0	100
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>1,550.0</b>	<b>3</b>	<b>1,550.0</b>	<b>100</b>

##### Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал тодорхойлогдоогүй байна.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 8,950.0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал илүү тооцож олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

##### 5.1 Зөвлөмж хүргүүлээгүй.

##### 5.2 Албан шаардлага хүргүүлээгүй

##### 5.3 Төлбөрийн акт

8,950.0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал илүү тооцож олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Үр дүнгийн урамшуулал буруу тооцож олгосон.	1	8,950.0					1	8,950.0				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>8,950.0</b>					<b>1</b>	<b>8,950.0</b>				

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА ОГНОО: 2024-02-22

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.БОЛДБААТАР ОГНОО: 2024-02-22

АХЛАХ АУДИТОР <sup>176</sup>

Ц.ОЮУНСУВД ОГНОО: 2024-02-22

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

ГЭРЭЭТ АУДИТОР

Г.УРАНБАЯР ОГНОО: 2024-02-22